



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2012 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 221

Улаанбаатар хот

“Цэгц капитал ББСБ” ХХК-ийн  
банк бус санхүүгийн гадаад валют арилжааны  
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг  
хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5, 14.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 186 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 10.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Цэгц капитал ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн гадаад валют арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.
2. Үйл ажиллагааны төрөлд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримтыг 2012 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Цэгц капитал ББСБ” ХХК /Э.Улсболд/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллах, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

001636